



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН
ХЭРЭГЖИЛТ ДҮГНЭХ ЕРӨНХИЙ АРГАЧЛАЛ**
(Санал авах хувилбар)

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилт дүгнэх ерөнхий аргачлал (цаашид “Аргачлал” гэх)-ын зорилго нь Харилцаа холбооны зохицуулах хороо болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд байгуулсан тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийн биелэлт хангагдаж байгаа эсэхийг тодорхойлох, хэрэгжилтийн түвшинг ахиулах, тогтмол хангуулахад оршино.
- 1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн хэрэгжилтийг үнэлэх үйл ажиллагаа нь баримт, нотолгоонд суурилсан, үндэслэл бүхий, ил тод, шуурхай, тасралтгүй байх зарчмыг удирдлага болгоно.
- 1.3. Энэхүү аргачлалын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний үүргийн хэрэгжилтийг хоёр жил тутамд дүгнэнэ.
- 1.4. Энэхүү аргачлалын 4.1.5-т зааснаас бусад мэдээлэл цуглуулах, үнэлэх болон нэгдсэн дүгнэлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлэх ажлыг цахим хэлбэрээр зохион байгуулна.

Хоёр. Үнэлгээ хийх ажлын зохион байгуулалт

- 2.1. Үнэлгээ хийх ажлын зохион байгуулалт нь дараах дараах үе шаттай байна:
 - 2.1.1. Төлөвлөх үе;
 - 2.1.2. Үнэлэх үе;
 - 2.1.3. Нэгдсэн үнэлгээ гаргах үе.

Гурав. Төлөвлөх үе шат

- 3.1. Холбогдох нэгж нь энэхүү аргачлалын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээг хоёр жил тутамд дүгнэх төлөвлөгөөг жил бүр гаргана.
- 3.2. Энэхүү аргачлалын 3.1-д заасан төлөвлөгөөнд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орон нутаг дахь салбарын үйлчилгээг хэсэгчлэн шалгах төлөвлөгөөг хамтад нь боловсруулна.
- 3.3. Холбогдох нэгж нь тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилт дүгнэх ажлыг тусгай зөвшөөрлийн төрөл, ангилал, цаг хугацаа, гарах зардлыг тооцон Харилцаа холбооны зохицуулах хорооны жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулна.

Дөрөв. Үнэлэх үе

- 4.1. Үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг дараах арга замаар цуглуулна:
 - 4.1.1 албан бичгээр шаардлагатай мэдээллийг авах;
 - 4.1.2 статистик мэдээ, тайланд өгсөн баримтад суурилах;
 - 4.1.3 мониторингийн дүнг үндэслэх;
 - 4.1.4 хэрэглэгчийн гомдол, шийдвэрлэлтийн байдалд үндэслэх;

- 4.1.5 тусгай зөвшөөрлийн гэрээний хүчинтэй хугацаанд хийгдсэн газар дээрх хэмжилт, хяналтын тайлан.
- 4.2. Тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтийг дараах үзүүлэлт, хувийн жингийн дагуу үнэлнэ:
- 4.2.1 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, журмын хэрэгжилтийн байдал нийт үнэлгээний 60 хувийг;
- 4.2.2 Тусгай зөвшөөрлийн гэрээний зохицуулалтын үйлчилгээний хөлс, радио давтамжийн ашиглалт үйлчилгээний төлбөр төлөлтийн байдал нийт үнэлгээний 30 хувийг;
- 4.2.3 Статистик мэдээ, тайлан ирүүлсэн байдал нийт үнэлгээний 10 хувийг эзэлнэ
- 4.3. Холбогдох нэгж нь энэхүү аргачлалын 4.2.1-т заасан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, журмын хэрэгжилтийг үнэлэхдээ энэхүү аргачлалын хавсралтаар баталсан маягтуудын дагуу тухайн тусгай зөвшөөрлийн төрөлд хамаарах шалгуур үзүүлэлтүүдийн хувийн жинг баримтална.
- 4.4. Холбогдох нэгж нь энэхүү аргачлалын 4.2-т заасан үнэлгээ бүрийг тоон үзүүлэлтээр гаргах бөгөөд үнэлгээний асуулт тус бүрийн хувьд:
- 4.4.1. хэрэгжсэн бол 2 оноо;
- 4.4.2. хэсэгчлэн хэрэгжсэн бол 1 оноо;
- 4.4.3. хэрэгжээгүй бол 0 оноогоор үнэлж, тухайн үзүүлэлтийн хувийн жинг харгалзах оноогоор үржүүлэн хувьчилж гаргана.
- 4.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү аргачлалын 4.1-т заасан мэдээлэл авах, газар дээрх хэмжилт, шалгалт хийх боломжоор хангаагүй тохиолдолд энэ тухай баталгаажуулж, тэмдэглэл үйлдэнэ.

Тав. Нэгдсэн дүгнэлт гаргах үе

5.1. Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар нь холбогдох нэгж тус бүрийн үнэлгээг нэгтгэж, энэхүү аргачлалын нэгдүгээр хавсралтад заасан маягтын дагуу нэгдсэн дүгнэлтийг гаргах бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн авсан онооноос хамааруулж дараах арга хэмжээний саналыг боловсруулна:

5.1.1. Нэгдсэн үнэлгээ 90 болон түүнээс дээш хувьтай гарсан тохиолдолд тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилт “бүрэн хангагдсан” гэж дүгнэнэ.

5.1.2. Нэгдсэн үнэлгээ 75-аас 89 хувьтай гарсан тохиолдолд тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилт “хэвийн” гэж дүгнэх бөгөөд хэрэгжилтийн түвшинг ахиулах зөвлөмжийг боловсруулна.

5.1.3. Нэгдсэн үнэлгээ 60-аас 74 хувьтай гарсан тохиолдолд тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтэд “сайжруулалт шаардлагатай” гэж үүрэг даалгавар хүргүүлэх саналыг боловсруулна.

5.1.4. Нэгдсэн үнэлгээ 60 ба түүнээс доош хувьтай гарсан тохиолдолд тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтийг “хангалтгүй” гэж үзэж тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу эхлүүлнэ.

5.2. Холбогдох нэгж нь нэгдсэн дүгнэлт болон гэрээний үүргийн хэрэгжилтийн түвшинг ахиулах, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд анхаарах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийн хамт тусгай зөвшөөрөл эзэмшигчид цахим системээр дамжуулан хүргүүлнэ.

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ НЭГДСЭН МАЯГТ**

1	Тусгай зөвшөөрлийн дугаар:			
2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр:			
3	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа:			
№	Үзүүлэлтүүд	Жигнэх хувь	Үнэлгээ өгөх нэгж	Хувь
1	Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, журмын хэрэгжилт	60 %	Холбогдох нэгж	
2	Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлс/радио давтамжийн ашиглалт үйлчилгээний төлбөр төлөлтийн байдал	30 %	ЗУХАГ	
3	Тусгай зөвшөөрлийн статистик тайлан, мэдээлэл ирүүлсэн байдал	10 %	ЗЗҮТЗГ	
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН (ДҮН1+ДҮН2+ДҮН3):				
ДҮГНЭЛТ:				
АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ:				
БАТАЛГААЖУУЛАЛТ:				
Үнэлгээ хийсэн:				
Албан тушаал:				
Огноо:				
Хянасан газрын дарга:				
Огноо:				

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨЛБӨР ТӨЛӨЛТИЙН
БАЙДЛЫГ ДҮГНЭХ ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ**

1	Тусгай зөвшөөрлийн дугаар:		
2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр:		
3	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа:		
№	Шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлага	Хувийн жин (ХЖ)	Биелэлтийн үнэлгээ
1	Тогтмол хугацаандаа төлдөг	15	Хэрэгжсэн - 100% Хэрэгжээгүй - 0%
2	Тухайн жилдээ багтаан төлсөн	10	Хэрэгжсэн - 100% Хэрэгжээгүй - 0%
3	Төлбөр төлөх эцсийн хугацаанаас 395 хоног хэтэрсэн	5	Хугацаа хэтэрсэн - 0% Хугацаа хэтрээгүй - 100%
	Нийлбэр оноо Авбал зохих оноо: АЗО=ХЖ		Авбал зохих оноо: 30
ДҮГНЭЛТ:			

“Тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилт дүгнэх ерөнхий аргачлал”-ын Гуравдугаар хавсралт

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭ, ТАЙЛАН
ИРҮҮЛСЭН БАЙДАЛ ДҮГНЭХ ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ**

1	Тусгай зөвшөөрлийн дугаар:		
2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр:		
3	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа:		
№	Шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлага	Хувийн жин (ХЖ)	Биелэлтийн үнэлгээ
1	Хугацаандаа тайлан ирүүлсэн. (үйл ажиллагаа явуулаагүй тухай албан бичиг)	4	Хэрэгжсэн – 4 Хэсэгчлэн хэрэгжсэн – 1-3 Хэрэгжээгүй - 0
2	Тайлангийн Үндсэн үзүүлэлт (задаргаагаар)	3	Хэрэгжсэн – 3 Хэсэгчлэн хэрэгжсэн – 1-2 Хэрэгжээгүй - 0
3	Тайлангийн Хавсралт үзүүлэлт (задаргаагаар)	3	Хэрэгжсэн – 3 Хэсэгчлэн хэрэгжсэн – 1-2 Хэрэгжээгүй - 0
	Нийлбэр оноо Авбал зохих оноо: АЗО=ХЖ	Авбал зохих оноо: 10	
ДҮГНЭЛТ:			

ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГА, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ МАЯГТ

Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.2, Шуудангийн тухай хуулийн 9.1.4, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.2, 1.3-т заасны дагуу Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх /шуудангийн сүлжээ байгуулах/, Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт хийхэд дараах маягтуудыг ашиглан нэгдсэн үнэлгээг гаргана. Үүнд:

Маягт А: Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх /шуудангийн сүлжээ байгуулах/ тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, журмын хэрэгжилтийг дүгнэх маягт

Маягт Б: Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, журмын хэрэгжилтийг дүгнэх маягт

Маягтууд нь дараах 2 агуулгын хүрээнд үнэлгээ хийгдэж, нийлбэр дүнгээр тооцогдоно. Үүнд:

1. Ерөнхий шаардлага
2. Бусад

Үнэлгээнд хамрагдах хугацаа: Үнэлгээг ажлын байрны үзлэг, гэрээний үүргийн талаар үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн тайлан мэдээнд үндэслэн 2 жил тутам үйлчилгээ эрхлэгч тус бүрээр гаргана.

Үнэлгээний биелэлтийн хувийг гаргах:

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 22, 23 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлага /Шуудангийн сүлжээ байгуулах/, Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтийг үйлчилгээ эрхлэгчдийн ажлын байранд очиж болон үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн тайланг үндэслэн дараах аргачлалын дагуу үнэлж, үнэлгээний дүнг гаргана. Үйлчилгээ эрхлэгч бүрийн хувьд нэгдсэн маягтын дагуу үзүүлэлт дүн тус бүрийн үнэлгээг хувийн жинд харгалзах оноогоор үржүүлэн тухайн үзүүлэлтийн үнэлгээг тооцно. Үзүүлэлт бүрийн үнэлгээний нийлбэр нь тухайн маягтын дагуу үнэлсэн НИЙТ ДҮН болно.

Нэгдсэн үнэлгээ гаргах аргачлал:

Аргачлалын дагуу үнэлэхдээ А маягт (Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлага /Шуудангийн сүлжээ байгуулах/), Б маягт (Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх) гэсэн 2 маягтыг ашиглана. Маягтын үзүүлэлтүүдэд үнэлгээг хэрэгжсэн бол 2, хэсэгчлэн хэрэгжсэн бол 1, хэрэгжээгүй бол 0 гэсэн оноогоор дүгнэнэ. Үзүүлэлтийн авбал зохих оноо нь хамгийн ихдээ 2 байна.

А маягт:

1. Ерөнхий шаардлага хэсэг 26 үзүүлэлттэй, үзүүлэлт бүрийг 2 оноогоор дүгнэнэ. Нийт 50 оноо авсан нь 100 хувьтай тэнцэнэ. Энэ нь нэгдсэн үнэлгээний маягтад эзлэх ач холбогдолын коэффициентоор тооцвол нийт 70 хувь болно.
2. Бусад хэсгийг 3 үзүүлэлттэй, үзүүлэлт бүрийг 2 оноогоор дүгнэнэ. Нийт 6 оноо авсан нь 100 хувьтай тэнцэнэ. Энэ нь нэгдсэн үнэлгээний маягтад эзлэх ач холбогдолын коэффициентоор тооцвол нийт 30 хувь болно.

А маягт нь нийт 2 хэсгийн 29 үзүүлэлттэй байна. Эдгээр 2 хэсэгт авсан оноог хооронд нь нэмснээр нийт дүн гарна.

Б маягт:

1. Ерөнхий шаардлага хэсэг 22 үзүүлэлттэй, үзүүлэлт бүрийг 2 оноогоор дүгнэнэ. Нийт 40 оноо авсан нь 100 хувьтай тэнцэнэ. Энэ нь нэгдсэн үнэлгээний маягтад эзлэх ач холбогдолын коэффициентоор тооцвол нийт 70 хувь болно.
2. Бусад хэсгийг 3 үзүүлэлттэй, үзүүлэлт бүрийг 2 оноогоор дүгнэнэ. Нийт 6 оноо авсан нь 100 хувьтай тэнцэнэ. Энэ нь нэгдсэн үнэлгээний маягтад эзлэх ач холбогдолын коэффициентоор тооцвол нийт 30 хувь болно.

Б маягт нь нийт 2 хэсгийн 25 үзүүлэлттэй байна. Эдгээр 2 хэсэгт авсан оноог хооронд нь нэмснээр нийт дүн гарна.

А. Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх /шуудангийн сүлжээ байгуулах/ тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, журмын хэрэгжилтийг дүгнэх маягт				
1	Ерөнхий шаардлага	Авбал зохих оноо	Хэмжүүр үзүүлэлт	Биелэлтийн үнэлгээ
1.1	Шуудангийн илгээмж хүлээн авч, ялган боловсруулах, солилцох солилцооны төвтэй байх.	2	Солилцооны төвтэй бол хэрэгжсэн, процессын хийгдэж байгаа бол хэсэгчлэн хэрэгжсэн, байхгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.2	Улс хоорондын шуудангийн ялган боловсруулах төв нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байх.	2	Ялган боловсруулах төвтэй бол хэрэгжсэн, процессын хийгдэж байгаа бол хэсэгчлэн хэрэгжсэн, байхгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.3	Шуудангийн илгээмжийг улс хооронд 1 буюу хэд хэдэн чиглэлээр тээвэрлэн, өөрийн харьяа салбар, эсхүл гэрээний үндсэн дээр гадаад улсын шуудангийн байгууллагын салбар /солилцооны төв/-аар дамжуулан үйлчлүүлэгчдэд хүргэх.	2	Процессыг бүрэн гүйцэтгэдэг бол хэрэгжсэн, процесс дутуу бол хэсэгчлэн хэрэгжсэн, огт гүйцэтгээгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0

1.4	Монгол Улсын нутаг дэвсгэрт (Улаанбаатар хот болон бүх аймгийн нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх тохиолдолд) шуудангийн илгээмжийг тээвэрлэн, өөрийн харьяа үйлчилгээний салбар цэгээр дамжуулан хүргэх	2	Процессыг бүрэн гүйцэтгэдэг бол хэрэгжсэн, процесс дутуу бол хэсэгчлэн хэрэгжсэн, огт гүйцэтгээгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.5	Шуудангийн сүлжээний үйлчлэгч нь шуудангийн аюулгүй байдлыг ханган, үйлчилгээг найдвартай, тасралтгүй хүргэх техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна.	2	Шуудангийн хэрэгсэл буюу шуудангийн илгээмж хүлээн авах, ялган боловсруулах, тээвэрлэх, хүргэхэд зориулсан тоног төхөөрөмж, шуудангийн богц, шуудангийн хайрцагтай бол хэрэгжсэн, дутуу бол хэсэгчлэн хэрэгжсэн, огт байхгүй бол хэрэгжээгүйд тооцно	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.6	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн дагуу эрх бүхий байгууллагад үйлчилгээний таних тэмдгээ бүртгүүлэн баталгаажуулж, хуулбарыг Зохицуулах хорооны Ажлын албанд ирүүлнэ.	2	Үйлчилгээний таних тэмдгээ Оюуны өмчийн газраар баталгаажуулан, гэрчилгээний хуулбарыг ирүүлсэн бол хэрэгжсэн, бүртгүүлэх процесс явагдаж байгаа, гэрчилгээний хуулбарыг ирүүлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн, огт баталгаажуулаагүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.7	Шуудан тээврийн ажиллагааг хэвийн тогтвортой явуулах нөөц тээврийн чиглэл, хуваарь бүхий	2	Төлөвлөгөөтэй бол хэрэгжсэн, төлөвлөгөө байхгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0

	төлөвлөгөөг баталсан байна.			
1.8	Гамшгийн үед ажиллах төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран баталж, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байх бөгөөд төлөвлөгөөг Зохицуулах хорооны Ажлын албанд тухай бүр ирүүлнэ.	2	Төлөвлөгөөг ХХЗХ-нд ирүүлсэн бол хэрэгжсэн, төлөвлөгөөтэй боловч ирүүлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн, төлөвлөгөө байхгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.9	Өөрийн сүлжээгээр бусад үйлчлэгчийн шуудангийн илгээмжийг чөлөөтэй дамжих нөхцөлийг бүрдүүлсэн харилцан холболтын зааглах цэгүүдийг сүлжээндээ тодорхойлсон байна.	2	Тодорхойлсон бол хэрэгжсэн, процесс хийгдэж байгаа бол хэсэгчлэн хэрэгжсэн, огт тодорхойлоогүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.10	Шуудангийн илгээмжийн бүртгэл, хяналтын цахим системийг технологи ажиллагаандаа нэвтрүүлж, хэвийн ажиллагааг хангасан байна.	2	Цахим системтэй бол хэрэгжсэн, систем нэвтрүүлэх процесс хийгдэж байгаа бол хэсэгчлэн хэрэгжсэн, систем байхгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.11	Шуудангийн тухай хуулийн 7.1.6-д заасан дүрмийн дагуу шуудангийн технологийн баримт бичгийг хадгалах зааврыг мөрдөн, архивыг бүрдүүлнэ.	2	Архивын материал шаардлага хангасан бол хэрэгжсэн, бүрдүүлэлт дутуу бол хэсэгчлэн хэрэгжсэн, байхгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.12	Шуудангийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу гарах шуудангийн	2	ХХЗХ-нд ирүүлж, хянуулсан бол хэрэгжсэн, хянуулаагүй бол	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0

	үйлчилгээний болон урамшууллын тарифыг Зохицуулах хороогоор хянуулж, баталж, мөрдөнө.		хэрэгжээгүйд тооцно.	
1.13	Хилийн чанад дах хамтран ажиллах байгууллага нэмэгдэх, мөн солигдох бүрт тухайн байгууллагатай хамтран ажиллах гэрээг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх;	2	ХХЗХ-нд бүртгүүлсэн бол хэрэгжсэн, бүртгүүлээгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.14	Шуудангийн сүлжээний үйлчлэгч нь Шуудангийн тухай хуулийн 9.1.6-д заасны дагуу Зохицуулах хорооноос тогтоосон шуудангийн илгээмж хүргэх хугацааг мөрдөж ажиллана.	2	Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох хяналтын ажлын үр дүнгээр хугацааг мөрдсөн бол хэрэгжсэн, мөрдөөгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.15	Энэхүү нөхцөл, шаардлагын 2.1.1.4-т тогтоосон хугацаанд хүргэсэн илгээмжийн гардуулалтын чанар тухайн жилдээ 95 хувиас багагүй байна.	2	Чанарын үзүүлэлт 95%-с дээш бол хэрэгжсэн, доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
Үйлчилгээний талаарх дараах мэдээллийг эрх бүхий этгээдээр батлуулж, байгууллагын цахим хуудас болон үйлчилгээний байран дахь мэдээллийн самбарт нээлттэй байршуулна.				
1.16	Үйлчилгээний тариф;	2	Хянуулж, батлуулсан тарифыг нээлттэй байршуулсан бол хэрэгжсэн, шинэчилсэн мэдээллийг нийтэд мэдээлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн,	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0

			нээлттэй байршуулаагүй бол хэрэгжээгүйд тооцно	
1.17	Шуудан хүргэх чиглэл, хуваарь болон илгээмж хүргэх хугацаа;	2	Мэдээллийг нээлттэй байршуулсан бол хэрэгжсэн, шинэчилсэн мэдээллийг нийтэд мэдээлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн, нээлттэй байршуулаагүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.18	Хаяг байршил, ажиллах цагийн хуваарь, холбоо барих мэдээлэл;	2	Мэдээллийг нээлттэй байршуулсан бол хэрэгжсэн, шинэчилсэн мэдээллийг нийтэд мэдээлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн, нээлттэй байршуулаагүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
Үйлчлэгч нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хуульд нийцсэн дараах журамтай байх бөгөөд үйлчлүүлэгчид нээлттэй байлгана.				
1.19	Илгээмжийн лавлагаа хүлээн авах, хариу өгөх журам;	2	Батлагдсан журмыг нээлттэй байршуулсан бол хэрэгжсэн, нийтэд мэдээлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн, журамгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.20	Үйлчлүүлэгчийн гомдол маргааныг хүлээн авах, шийдвэрлэх, хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгох журам;	2	Батлагдсан журмыг нээлттэй байршуулсан бол хэрэгжсэн, нийтэд мэдээлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн, журамгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
	Стандарт			

1.21	ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ШААРДЛАГА MNS 6776:2019	2	Стандартыг 90%-с дээш мөрдсөн бол хэрэгжсэн, 70%-89% бол хэсэгчлэн хэрэгжсэн, 69%-иас доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.22	ХАЯГ, ХАЯГИЙН БИЧВЭРТ ТАВИХ ШААРДЛАГА MNS 6775:2024	2	Стандартыг 90%-с дээш мөрдсөн бол хэрэгжсэн, 70%-89% бол хэсэгчлэн хэрэгжсэн, 69%-иас доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.23	ШУУДАНГИЙН АЖЛЫН БАЙР MNS 5540:2005	2	Стандартыг 90%-с дээш мөрдсөн бол хэрэгжсэн, 70%-89% бол хэсэгчлэн хэрэгжсэн, 69%-иас доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.24	ШУУДАНГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ MNS 5539:2019	2	Стандартыг 90%-с дээш мөрдсөн бол хэрэгжсэн, 70%-89% бол хэсэгчлэн хэрэгжсэн, 69%-иас доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.25	МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН БАЙРАНД ТАВИХ ШААРДЛАГА MNS 5882:2008	2	Стандартыг 90%-с дээш мөрдсөн бол хэрэгжсэн, 70%-89% бол хэсэгчлэн хэрэгжсэн, 69%-иас доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.26	МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАНД ТАВИХ ШААРДЛАГА MNS 5881:2008	2	Дүрэмт хувцастай бол хэрэгжсэн, байхгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
ДҮН /АХК=70%				
ҮНЭЛГЭЭ Х*100/26				
2	Бусад			

2.1	Гаалийн зөрчил	2	Гаалийн зөрчилгүй бол хэрэгжсэн, 1 зөрчилтэй бол хэсэгчлэн хэрэгжсэн, олон зөрчилтэй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
2.2	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын дүн	2	81-100% бол хэрэгжсэн, 61-80% бол хэсэгчлэн хэрэгжсэн, 60-аас доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
2.3	Хугацаатай үүрэг, даалгаврын биелэлт	2	81-100% бол хэрэгжсэн, 61-80% бол хэсэгчлэн хэрэгжсэн, 60-аас доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
	Дүн /АХК=30%			
	Үнэлгээ $x*100/3$			
Үнэлсэн албан тушаалтан:				
Байлцсан албан тушаалтны нэр				
Авсан нийт дүн:		ДҮН1+ДҮН2		
Огноо:				
Анхаарах шаардлагатай асуудлууд:				

Б. Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, журмын хэрэгжилтийг дүгнэх маягт				
1	Ерөнхий шаардлага	Хувийн жин	Хэмжүүр үзүүлэлт	Биелэлтийн үнэлгээ
1.1	Шуудангийн тухай хуулийн 15.1 дэх хэсэгт заасан шуудангийн үйлчилгээг тасралтгүй явуулах техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна.	2	Шуудангийн хэрэгсэл буюу шуудангийн илгээмж хүлээн авах, ялган боловсруулах, тээвэрлэх, хүргэхэд зориулсан тоног төхөөрөмж, шуудангийн богц, шуудангийн хайрцагтай бол хэрэгжсэн, дутуу бол хэсэгчлэн хэрэгжсэн, огт байхгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.2	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн дагуу эрх бүхий байгууллагад үйлчилгээний таних тэмдгээ бүртгүүлэн баталгаажуулж, хуулбарыг Зохицуулах хорооны Ажлын албанд ирүүлнэ	2	Үйлчилгээний таних тэмдгээ Оюуны өмчийн газраар баталгаажуулан, гэрчилгээний хуулбарыг ирүүлсэн бол хэрэгжсэн, бүртгүүлэх процесс явагдаж байгаа, гэрчилгээний хуулбарыг ирүүлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн, огт баталгаажуулаагүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.3	Шуудангийн тухай хуулийн 19.2-т заасан шуудангийн үндсэн болон буухиа шуудангаар үйлчлэгч нь энэхүү нөхцөл, шаардлагын 3.5-т заасны дагуу баталгаажуулсан өөрийн таних тэмдэг бүхий илгээмжийн зориулалтын хайрцаг, сав, баглаа боодол, битүүмжлэлийн наалт болон бичиг захидал,	2	Ашиглаж байгаа бол бүрэн хэрэгжсэн, зарим хэрэглэгдэхүүн дутуу бол хэсэгчлэн хэрэгжсэн, ашиглахгүй байгаа бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0

	боодлын дугтуйг ашиглана			
1.4	Шуудангийн бусад үйлчлэгчтэй харилцан холболт хийх зааглах цэгийг тодорхойлж, илгээмжийг чөлөөтэй дамжих нөхцөлийг бүрдүүлж, харилцан холболтын тарифыг Зохицуулах хороогоор хянуулсан байна.	2	ХХЗХ-нд ирүүлж, хянуулсан бол хэрэгжсэн, хянуулаагүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.5	Гамшгийн үед ажиллах төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран баталж, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байх бөгөөд төлөвлөгөөг Зохицуулах хорооны Ажлын албанд тухай бүр ирүүлнэ.	2	Төлөвлөгөөг ХХЗХ-нд ирүүлсэн бол хэрэгжсэн, төлөвлөгөөтэй боловч ирүүлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн, төлөвлөгөө байхгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.6	Шуудангийн илгээмжийн бүртгэл, хяналтын цахим системийг технологи ажиллагаандаа нэвтрүүлж, хэвийн ажиллагааг хангана.	2	Цахим системтэй бол хэрэгжсэн, систем нэвтрүүлж байгаа порцесс хийгдэж байгаа бол хэсэгчлэн хэрэгжсэн, систем байхгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.7	Шуудангийн тухай хуулийн 7.1.6-д заасан дүрмийн дагуу шуудангийн технологийн баримт бичгийг хадгалах зааврыг мөрдөн, архивыг бүрдүүлнэ.	2	Архивын материал шаардлага хангасан бол хэрэгжсэн, бүрдүүлэлт дутуу бол хэсэгчлэн хэрэгжсэн, байхгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0

1.8	Шуудангийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу гарах шуудангийн үйлчилгээний болон урамшууллын тарифыг Зохицуулах хороогоор хянуулж, баталж, мөрдөнө.	2	ХХЗХ-нд ирүүлж, хянуулсан бол хэрэгжсэн, хянуулаагүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.9	Хилийн чанад дах хамтран ажиллах байгууллага нэмэгдэх, мөн солигдох бүрт тухайн байгууллагатай хамтран ажиллах гэрээг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх.	2	ХХЗХ-нд бүртгүүлсэн бол хэрэгжсэн, бүртгүүлээгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.10	Үйлчлэгч нь Шуудангийн тухай хуулийн 9.1.6-д заасны дагуу Зохицуулах хорооноос тогтоосон шуудангийн илгээмж хүргэх хугацааг мөрдөж ажиллана.	2	Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох хяналтын ажлын үр дүнгээр хугацааг мөрдсөн бол хэрэгжсэн, мөрдөөгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.11	Энэхүү нөхцөл, шаардлагын 2.1.1.4-т тогтоосон хугацаанд хүргэсэн илгээмжийн гардуулалтын чанар тухайн жилдээ 95 хувиас багагүй байна.	2	Чанарын үзүүлэлт 95%-с дээш бол хэрэгжсэн, доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
Үйлчилгээний талаарх дараах мэдээллийг эрх бүхий этгээдээр батлуулж, байгууллагын цахим хуудас болон үйлчилгээний байран дахь мэдээллийн самбарт нээлттэй байршуулна.				

1.12	Үйлчилгээний тариф;	2	Хянуулж, батлуулсан тарифыг нээлттэй байршуулсан бол хэрэгжсэн, шинэчилсэн мэдээллийг нийтэд мэдээлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн, нээлттэй байршуулаагүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.13	Шуудан хүргэх чиглэл, хуваарь болон илгээмж хүргэх хугацаа;	2	Мэдээллийг нээлттэй байршуулсан бол хэрэгжсэн, шинэчилсэн мэдээллийг нийтэд мэдээлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн, нээлттэй байршуулаагүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.14	Хаяг байршил, ажиллах цагийн хуваарь, холбоо барих мэдээлэл;	2	Мэдээллийг нээлттэй байршуулсан бол хэрэгжсэн, шинэчилсэн мэдээллийг нийтэд мэдээлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн, нээлттэй байршуулаагүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
Үйлчлэгч нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хуульд нийцсэн дараах журамтай байх бөгөөд үйлчлүүлэгчид нээлттэй байлгана.				
1.15	Илгээмжийн лавлагаа хүлээн авах, хариу өгөх журам;	2	Батлагдсан журмыг нээлттэй байршуулсан бол хэрэгжсэн, нийтэд мэдээлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн, журамгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.16	Үйлчлүүлэгчийн гомдол маргааныг хүлээн авах, шийдвэрлэх, хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгох журам;	2	Батлагдсан журмыг нээлттэй байршуулсан бол хэрэгжсэн, нийтэд мэдээлээгүй бол хэсэгчлэн хэрэгжсэн, журамгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
Стандарт				

1.17	ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ШААРДЛАГА MNS 6776:2019	2	Стандартыг 90%-с дээш мөрдсөн бол хэрэгжсэн, 70%-89% бол хэсэгчлэн хэрэгжсэн, 69%-иас доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.18	ХАЯГ, ХАЯГИЙН БИЧВЭРТ ТАВИХ ШААРДЛАГА MNS 6775:2024	2	Стандартыг 90%-с дээш мөрдсөн бол хэрэгжсэн, 70%-89% бол хэсэгчлэн хэрэгжсэн, 69%-иас доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.19	ШУУДАНГИЙН АЖЛЫН БАЙР MNS 5540:2005	2	Стандартыг 90%-с дээш мөрдсөн бол хэрэгжсэн, 70%-89% бол хэсэгчлэн хэрэгжсэн, 69%-иас доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.20	ШУУДАНГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ MNS 5539:2019	2	Стандартыг 90%-с дээш мөрдсөн бол хэрэгжсэн, 70%-89% бол хэсэгчлэн хэрэгжсэн, 69%-иас доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.21	МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН БАЙРАНД ТАВИХ ШААРДЛАГА MNS 5882:2008	2	Стандартыг 90%-с дээш мөрдсөн бол хэрэгжсэн, 70%-89% бол хэсэгчлэн хэрэгжсэн, 69%-иас доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
1.22	МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАНД ТАВИХ ШААРДЛАГА MNS 5881:2008	2	Дүрэмт хувцастай бол хэрэгжсэн, байхгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
Дүн /АХК=70%				
Үнэлгээ х*100/22				
2	Бусад			
2.1	Гаалийн зөрчил	2	Гаалийн зөрчилгүй бол хэрэгжсэн, 1 зөрчилтэй бол хэсэгчлэн хэрэгжсэн, олон зөрчилтэй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
2.2	Төлөвлөгөөт болон	2	81-100% бол хэрэгжсэн, 61-80%	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1

	төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын дүн		бол хэсэгчлэн хэрэгжсэн, 60-аас доош бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжээгүй -0
2.3	Хугацаатай үүрэг, даалгаврын биелэлт	2	Бүрэн биелүүлсэн бол хэрэгжсэн, дутуу бол хэсэгчлэн хэрэгжсэн, биелүүлээгүй бол хэрэгжээгүйд тооцно.	хэрэгжсэн – 2 хэсэгчлэн хэрэгжсэн – 1 хэрэгжээгүй -0
	Дүн /АХК=30%			
	Үнэлгээ $x*100/3$			
Үнэлсэн албан тушаалтан:				
Байлцсан албан тушаалтны нэр				
Авсан нийт дүн:		ДҮН1+ДҮН2		
Огноо:				
Анхаарах шаардлагатай асуудлууд:				